



Бурхан бол бидний Багш Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол бидний Багш

Attribute: God Is Our Teacher

Тодорхойлолт: Удирддаг, зааварладаг мэдлэгийг өвлүүлдэг Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Иов 36:22** Харагтун, Бурхан хүч дотроо өргөмжлөгджээ. Харин Түүн шиг багш хэн бэ?
- **Дуулал 32:8** Би явах ёстой замд чинь чамд зааварлан зааж өгнө Нүд минь чамайг ширтэн чамд зөвлөнө.
- **Исаиа 48:17** Чиний Аврагч, Израилийн Ариун Нэгэн, ЭЗЭН Ингэж айлдаж байна. Чамд тустайг сурган Чамайг явах замаар чинь удирддаг “Бурхан ЭЗЭН чинь Би байна.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Дуулал 25:4-5; Исаиа 48:17

Библийн эшлэлээр залбирах:

(Хүүхдийн нэр)-д маань Өөрийн Арга замыг үзүүлээч, Өө Эзээн, түүнд Өөрийн замыг заагаач, Өөрийн үнэн дотор (Хүүхдийн нэр)-ийг маань удирдаач, Та Өөрийгөө түүний Бурхан, Аврагч Эзэн гэдгийг заагаач; (Хүүхдийн нэр) маань банд бүхий л өдөржин өөрийн итгэл найдварыг тавих болтугай. Хүүхдэд маань юу хамгийн сайн гэдгийг зааж байгаа Эзэн Тандаа баярлалаа, явах ёстой замаар нь Та түүнийг минь явуулж байгаа учраас баярлалаа.

Залбирлын тодорхой хүсэлт:

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- _____-д маань Өөрийн Арга замыг үзүүлээч, Өө Эзээн, түүнд Өөрийн замыг заагаач, Өөрийн үнэн дотор _____-ийг маань удирдаач, Та Өөрийгөө түүний Бурхан, Аврагч Эзэн гэдгийг заагаач; _____ маань банд бүхий л өдөржин өөрийн итгэл найдварыг тавих болтугай. Хүүхдэд маань юу хамгийн сайн гэдгийг зааж байгаа Эзэн Тандаа баярлалаа, явах ёстой замаар нь Та түүнийг минь явуулж байгаа учраас баярлалаа. *Дуулал 25:4-5; Исаиа 48:17*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!